

С.БОЛДХЭТ

Наран Группын төлөөлөн
удирдах зөвлөлийн дарга

МОНГОЛ УЛСАД ГАДААД ХУДАЛДААНЫ ЯАМ ХЭРЭГТЭЙ БАЙНА

V НҮҮРТ

ЗЭЭЛИЙН ХҮҮГ

Хязгаарлах тухайг

(үргэлжлэл)

Эдүгээ улсын валютын нөөц 3 тэрбум ам. долларт хүрсэн, төсвийн алдагдал 2 их наяд төгрөгөөр, ЗГ-ын үнэт цаасны үлдэгдэл 1 их наяд төгрөгөөр тус тус буураад байна. Эдийн засаг нэг хувийн өсөлтөөс 4-5 хувийн өсөлттэй орчин руу шилжсэн, гадаад эдийн засгийн орчин сайжирч, тогтвортой байх болсон зэрэг эерэг хандлагууд байна.

III НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.02.21, №35

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

ЗЭЭЛИЙН ХҮҮГ

Хязгаарлах тухайг

(үргэлжлэл)





RADO TRUE AUTOMATIC DIAMONDS
PLASMA HIGH-TECH CERAMIC. METALLIC LOOK. MODERN ALCHEMY.

RADO
S W I T Z E R L A N D

TIME IS THE ESSENCE WE ARE MADE OF

*Хаяг: Наран Молл, 2-р давхар, Сөүлийн гудамж.
Наран Центр, УИД-н баруун талд.*

*Утас: 99073568
Утас: 99073568*



№ 419

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

DeFacto

МЭТГЭЛЦЭЭН

ЗЭЭДИЙН ХҮҮГ

Хязгаарлах тухайг (үргэлжлэл)

НЯЦААГЧ ТАЛ

Эдүгээ улсын валютын нөөц 3 тэрбум ам. долларт хүрсэн, төсвийн алдагдал 2 их наяд төгрөгөөр, ЗГ-ын үнэт цаасны үлдэгдэл 1 их наяд төгрөгөөр тус тус буураад байна. Эдийн засаг нэг хувийн өсөлтөөс 4-5 хувийн өсөлттэй орчин руу шилжсэн, гадаад эдийн засгийн орчин сайжирч, тогтвортой байх болсон зэрэг эерэг хандлагууд байна.

Монголын эдийн засаг 2017 оны байдлаар жилийн өмнөхтэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт ба гадаад актив талаасаа дараах өөрчлөлтүүд гарсан. Нүүрсний орлого 1.3 тэрбум ам. доллараар, ГХО 1.3 тэрбум доллар болж өссөн байна. ОУВС-ийн хөтөлбөрийн зээл, гадаадын ЗГ-уудаас олгох зээл, ЗГ-ын гадаад зах зээлд арилжаалсан бондын эх үүсвэр, алтны мөнгөжүүлэлт, интервенц зэрэг шалтгаанаар валютын нөөц өссөн гэх мэтээр 4 тэрбум орчим ам. долларын гадаад валютын орох урсгал 2017 онд эдийн засагт бий болсон байна.

Хүү өндөр байгаа бол эрсдлийн түвшин өндөр байгаа гэсэн үг. Тэгэхээр нийт эдийн засгийн эрсдлийг бууруулах, эрсдлийг өндөр болгож буй хүчин зүйлүүдтэй нь тэмцэх, эдийн засгийн суурь асуудлуудтайгаа төр ажиллах хэрэгтэй. Тэгэхгүйгээр асуудлын шинж тэмдэгтэй тэмцэх нь агуулгагүй.

Иймээс инфляцийг нам түвшинд тогтвортой байлгах, гадаад актив өсч байгаа эерэг орчинд дотоод актив аа өсгөх бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй. Ингэхдээ зөвхөн хэрэглээг биш эдийн засгийн бүтцийг дэмжих, зөв бүтэц рүү явуулах. Ажлын байр, дотоодын хөрөнгө оруулалт, хуримтлал, дундаж давхарга руу, хөдөө аж ахуй, органик хүнсний үйлдвэрлэл рүү санхүүжилт хийх хэрэгтэй. Энэ эрх мэдэл төрд хангалттай бий.



ДЭМЖИГЧ ТАЛ

Арилжааны банкуудын сүүлийн 4 жилийн тайлан, балансыг харвал банкууд өөрсдөө хадгаламжийн хүүгийн зардлаа төлж чадахгүй түвшинд хүрчээ. Монголбанкнаас гаргаж буй банкуудын нэгдсэн тайлан, балансаар банкны систем 2017 оны эцсээр 240 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Эндээс банкууд ашигтай ажиллаж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа гэж ойлгоно. Гэвч бодит байдал шал өөр.

Яагаад гэвэл 240 тэрбумын цэвэр ашигтай ажиллах гэж ЗГ-аас, Төв Банкнаас 600-700 тэрбум төгрөг авчихсан. Сүүлийн гурав дөрвөн жил арилжааны

банкууд бизнест бараг зээл олгосонгүй. Тэд ажлаа хийхгүй болсон.

Тэр гаргаагүй зээлийг нь татвар төлөгчдийн хөрөнгөөр төр санхүүжүүлж жилд 600-700 тэрбум төгрөгийг банкуудад өгч байсан. Энэ 240 тэрбум төгрөгийн цэвэр ашиг гэдэг нь банкууд үндсэн үйл ажиллагаанаасаа жилд 400-500 тэрбум төгрөгийн алдагдалтай байгааг харуулж байна. Энэ бол өнөөдрийн банкны систем буруу яваад байгаагийн тод илрэл юм. Хүүлэлтийн эсрэг хууль гарч байж л банкууд цаашдаа оршин тогтноно.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ҮРГЭЛЖЛЭХ ЭСЭХ ТУХАЙ АСУУЛТАД НЯЦААГЧ ТАЛЫН ХАРИУЛТ:

Мөнгө зээлийн бодлогын хүрээнд аливаа улсын төр нь тухайлсан нэг бодлогын хүрээнд зорилтот сегментийг, салбарыг чухал гэж үзээд тодорхой санхүүгийн эх үүсвэр бий болгон дэмжиж болно. Орон сууцны 8 хувийн зээл бол тийм эх үүсвэртэй хөтөлбөр юм. Монголд хуримтлал хийдэг дундаж давхаргыг

том болгох зорилгоор хямралын үеэр эхлүүлсэн, эх үүсвэртэй бодлого. Тухайн үед банкууд өөрийн эх үүсвэрээр дунджаар 16-17 хувьтай ипотекийн зээл олгож байсан тул хориод жилд нийтдээ гучин мянган хүнээс хэтрээгүй юм.

ИНФЛЯЦИ БА ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГИЙН ХОЛБООСЫН ТУХАЙ ДЭМЖИГЧ ТАЛЫН ХАРИУЛТ:

Хүн төрөлхтний түүхэнд бүхий л улс орон инфляцитай тулгарч ирсэн. Энэ бол зөвхөн монголын биш, дэлхий нийтийн асуудал. Манай санхүүгийн зах зээл болон эдийн засагт хадгаламжийн хүү инфляциас дээр байх ёстой гэдэг хамгийн буруу ойлголт байдаг. Төр, Төв банк болон арилжааны банкуудын бодлого ийм чиглэлд явж ирлээ.

Хуримтлалтай хүн одоогийн 9900 биш 99 мянга

бүр 990 мянга болох ёстой. Тэгж л улс орон хөгжинө. Сүүлийн 27 жилд зөвхөн хуримтлалтай 9900 хүнээ л инфляциас нь хамгаалсаар явж ирлээ. Гэтэл инфляци 8 хувь боллоо гэхэд тухайн эдийн засагт байгаа бүх хүний мөнгөнөөс 8 хувийг төр авдаг гэсэн үг. Тэгээд бүх хүнээс авсан мөнгөөр хуримтлалтай 9900 хүний инфляцийг нөхөж өгчихөөд байгаа хэрэг.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ХЭЗЭЭ ХӨГЖИХ ТУХАЙ АСУУЛТАД ДЭМЖИГЧ ТАЛААС ХАРИУЛСАН НЬ:

Өнөөдөр монголын санхүүгийн зах зээл зөвхөн банкинд суурилчихаад байна. Хөрөнгийн зах зээл яагаад хөгжихгүй байгаад гурван шалтгаан байна.

Нэгдүгээрт, хуучин банкны хадгаламжийн хуулиар банкуудаас нэг ч төгрөг авалгүйгээр, төр банкинд дахь бүх хадгаламжийг батлан даадаг байсан.

Хоёрдугаарт, татварын эрх тэгш бус зохицуулалт 27 жил үргэлжилсэн. Банкны мөнгөө хадгалуулаад авч буй хүүгийн орлогоос татвар авдаггүй байсан. Гэтэл хувьцаа, үнэт цаас худалдаж авбал татвартай. Харин өнгөрсөн жил ОУВС-ийн шахалтын үр дүнд анх удаа

банкны хүүгийн орлогоос татвар авдаг болсон.

Гуравдугаарт, төрөөс болон Азийн Хөгжлийн Банк (АХБ), Дэлхийн Банкны (ДБ) хэрэгжүүлж байгаа бүх төсөл, хөтөлбөр бусад үйл ажиллагааны санхүүжилт нь арилжааны банкуудаар дамждаг. Төрөөс Хөрөнгийн бирж, брокерын компаниудыг дэмждэггүй. Ер нь төрийн бодлогоор хөрөнгийн зах зээл монголд хөгжсөнгүй.

2018.02.21



С.БОЛДХЭТ

Наран Группын төлөөлөн
удирдах зөвлөлийн дарга

ДеФакто ЯРИЛЦЛАГА

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

МОНГОЛ УЛСАД ГАДААД ХУДАЛДААНЫ ЯАМ ХЭРЭГТЭЙ БАЙНА

Сэрээтэр овогтой Болдхэт нь олон улсын эдийн засгийн харилцааны мэргэжилтэй. Орос, Англи, Франц хэлтэй. 1976 оноос ажлын гараагаа эхлэж Гадаад худалдааны яам, Япон "Монголимпекс", "Монгол экспорт" нэгдэлд Конторын дарга, Сингапур улсад ХТГ-д Худалдааны зөвлөх, Консул зэрэг ажлыг 20 гаруй жил хийж Монгол улсын гадаад дотоод худалдааг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулсан.

Д.Ж: Та Монгол улсын гадаад дотоод худалдааны салбарт мөн төр засагт ажиллаж байсан арвин туршлагатай хүн. Та манай анхны Сингапурт сууж байгаа худалдааны төлөөлөгч байсан, консулаар ажилласан. Бас ардчилсан хувьсгалд оролцсон. Их хурлын гишүүн байсан. Энэ утгаараа хоёулаа макро эдийн засгийн асуудлыг яримаар байна. Юуны өмнө Монгол улсын эдийн засаг тасралтгүй хямраад л байна. Та үүнийг хамгийн түрүүнд мэдэж, мэдэрч байгаа хүмүүсийн нэг. Асуудлын шалтгаан нь юу юм бэ?

С.Б: Та бид хоёр бол хоёр нийгэм, хоёр зууныг дамжаад ирсэн хүмүүс. Тэр үед Гадаад худалдааны яам гэж байсан. Гадаад худалдааны нэгдлүүд гэж байсан. Импортын экспортын нэгдлүүд байсан. Энэ үед төрөлжиж, худалдааг улс гартаа авсан ийм үе байсан. Зөвхөн экспорт, импорт төдийгүй жижиглэн, бөөнийх гээд бүгд улсын мэдэлд байлаа. Социализмын сүүлийн 10-аад жилд нааштай зүйлүүд гарч эхэлсэн. Тухайлбал дэлхийн зах зээлийг судлах, үнэ бүрдэлтийг судлах, өөрсдийн экспорт импортод арай олон эх үүсвэрээс авах, өрсөлдөөний утгыг ойлгох зэрэг. Гадаад худалдааны яаманд эдийн засаг, өрсөлдөгч, дэлхийн зах зээлийг судалдаг "Эдийн засгийн газар" гэж байлаа. Дараа нь Үнэ эдийн засаг, коннектурын институт гэж хүртэл байгуулагдаж байсан. Энэ нь аль болох өөрийн орны экспортын барааг дэлхийн зах зээлийн үнэд аль болох хүргэх, импортын ганц хоёр эх үүсвэрээс биш хэд хэдэн эх үүсвэрээс судалж авах зэргийг зохицуулдаг байсан. Тэр үед ярьж байсан шүү дээ. Хүүхдийн нэг тоглоомон морь манай амьд адууны үнэтэй байлаа гээд. Ингээд ардчилал гараад ирсний дараагаар энэ институт үндсэндээ алга болж байгаа юм. Худалдаа үндсэндээ хувийн хэвшилд шилжээд үнийн асуудал, үнийг судлах асуудал, зах зээл судлах асуудал байхгүй. Зэрлэг капитализм маягаар ингээд явчихсан. Энэ нь их алдагдалтай зүйл болсон л доо. Одоо ч гэсэн үргэлжилсээр л байна. Жишээлбэл бид байгалийн баялгаа, нүүрсээ ямар үнээр зарж байна вэ? Гадаадаас импортоор ямар үнээр авч байна? Энд ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Зохицуулалт гэхээр яам, тамгын газар эрх, лицензийг нь өгөөд л чөлөөт зах зээлийн бодлогоо устгана гэсэн утгаар биш. Тодорхой хэмжээний мэдээлэл л өгөх хэрэгтэй

байхгүй юу! Жишээлбэл цагаан сар, шинэ жил гээд л баахан бараа таваар орж ирнэ. Ингэж их хэмжээгээр орж ирэхээр зах зээл дээр илүүднэ. Үүнд зохицуулалт бас л байхгүй. Зах зээлийн багтаамж нь энэ шүү, үүнээс хэтрэхээр ийм болно шүү гэдгийг нь ярихаас биш тас хаагаад хориглоно гэсэн утгаараа биш л дээ.

Д.Ж: Нэгдсэн мэдээлэл өгч байгаач гэж байна, тиймээ?

С.Б: Тийм. Нэгдсэн мэдээллийн систем боловсруулах хэрэгтэй байна.

Д.Ж: Энэ мэдээлэл яагаад байхгүй байгаа юм бэ? Жишээ нь Худалдаа аж үйлдвэрийн танхим өгөх ёсгүй юмуу?

С.Б: Хуучин бол Гадаад худалдааны яам байсан. Одоо бол гадаад худалдааны бүх систем чинь Гадаад харилцааны яаманд оччихсон юм байна л даа. Энд бол нэг яамны хавсарга хэлтэс хэмжээнд л байгаа юм. Тэгэхээр Гадаад харилцааны яам гэдэг чинь өөрөө их өргөн хүрээгээр ажилладаг байгууллага учраас цаг зав, анхаарал нь тэр болгон хүрэхгүй байгаа юм. Гадаадад ажиллаж байгаа Элчин сайдууд нь ч гэсэн гадаад худалдааны тал дээр учир дутагдалтай, мэргэжлийн биш. Миний бодлоор хамгийн чухал агентлаг бол Гадаад худалдааны агентлаг юмуу гадаад худалдааг судалж байдаг, өрсөлдөгчөө судалж байдаг тийм агентлаг байх хэрэгтэй байх шиг байгаа юм. Яам байвал бүр сайн. Худалдаа үйлдвэрийн яам гэж бүх улсад байдаг шүү дээ.

Д.Ж: Та зохицуулалт гэдгийг мэдээллээр илүү хангаад, зах зээлээ судлаад олон нийтэд хүргээд өгөөчээ гэж хэлж байгаа юм байна, тиймүү?

С.Б: Тиймээ, тэр болгоныг хувийн компаниуд сайн судалж чадахгүй байна л даа. Монгол улсын экспорт юунаас бүрддэг билээ? Эдийн засаг юунаас бүрддэг билээ? гэдгийг мэргэжлийн экспортууд судлах хэрэгтэй байгаа юм. Импорт бол тодорхой.

Д.Ж: Та Наран группын талаар товч ярьж өгөөч?

С.Б: Наран группыг мэдэхгүй хүн одоо байхгүй дээ. 1990 оны ардчилсан хувьсгалтай эн зэрэгцээд одоо 28 жил явж байна. Олон мянган хүнийг ажлын байраар хангасан. Олон зуун тэрбум төгрөгийг татварт өгсөн. Хамгийн гол ашгийг би юу гэж үздэг вэ гэвэл олон хүнийг зөвхөн ажлын байраар хангах бус өөрийгөө аваад явах амьдралын хэв маягт сургах, зах зээлийн сэтгэлгээг суулгах гэсэн энэ зүйлд бид анхаарлаа хандуулдаг. Дээр нь монголд амьдралын шинэ хэв маягийг бий болгож байгаа. Бид нар чинь социализмын үеийн тодорхой хэмжээгээр хоцрогдсон, бүдүүн бараг ард түмэн байсан шүү дээ. Тэгэхээр нь үүнийг дэлхийн хөгжилтэй уялдуулъя, хэрэглээг нь боловсронгуй болгоё. Нөгөө талаар хүнд бас сонгох эрх байх ёстой шүү дээ. Ингэж байж хүн төрөлхтний 21-р зуунд мөр зэрэгцэж явна шүү дээ.

Д.Ж: Харин тийм. Танай оруулж ирж байгаа бараануудад дээд зэрэглэлийн бараанууд их байдаг. Үүний бодлого нь юу юм бэ? Бусад оронд хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг монголчууд бас хэрэглэх хэрэгтэй гээд оруулж ирээд байх шиг байна, тиймүү? Гэхдээ том брэндийг төлөөлж ажиллах бол зүгээр нэг бараа авчраад зарах шиг тийм амар зүйл биш. Энд ямар шаардлага тавигддаг юм бэ?

С.Б: Энэ дээр хүмүүст зөв ойлголт өгөх хэрэгтэй. Үйлдвэр байгуулахгүй, зүгээр нэг гаднаас бараа оруулж ирж зараад л, хялбар замаар ажиллаж байгаа нөхдүүд гэж худалдааныхныг ойлгоод байна л даа. Гэтэл үүнд бас ухагдахуун байгаад байгаа юм. Ер нь худалдаа бол хөгжлийг авчирдаг. Манайд төрөл бүрийн бараа орж ирж байна. Энэ төрөл бүрийн барааг хараад манай үйлдвэрлэгч нар үүнтэй зэрэгцэж чанараа сайжруулах шаардлагатай болно. Зах зээлд яавал өрсөлдөх үү? гэдгээ бодно. Хэрвээ зах зээлээ хаачихвал дотоодоосоо бүх юмаа авах болно. Тэгвэл манай улс хөгжихгүй. Дэлхийн стандарт ч хаана билээ. Ийм л болно. Социализмын үед жишээ нь гутлыг өөрсдөө үйлдвэрлэх гээд зорьж байсныг санах хэрэгтэй. Үүнийг үе шаттай хийх хэрэгтэй. Брэнд гэдэг ойлголт нь нөгөө талаар монгол хүн үг хэлэх эрх гэдэг шиг хэрэглээний эрх, сонгох эрх гэж би яриад байгаа. Ард түмэндээ дэлхийн хөгжил, дэлхийн брэндүүд, худалдааны хөгжил болон соёлыг нэвтрүүлсэн гэж ойлгоод байгаа юм. Худалдааг дээр хэлсэнчлэн худалдааны бодлогоор л зохицуулна.

Нөгөө талаар бидний бодлого ямар байсан бэ гэвэл худалдааны салбар бүр мөсөн уначихсан байсан учраас ард түмнээ өргөн хэрэгцээний бараагаар хангах. Худалдааны салбарын ажиллагсдын гол зорилго нь энэ. Энэ хэрэгцээ ерөнхийдөө хангагдаад ирэхээр арай чанаржуулах асуудал. Чанаржуулна гэдэг чинь дахиад л улсын эдийн засаг болон валютыг хэмнэж байгаа хэрэг. Хэрэгтэй хэрэггүй бүтээгдэхүүн аваад л, дахиад өөр газраас импортлоод л. Ард түмний гар дээр байгаа

мөнгө чинь бас улс орны баялаг шүү дээ. Чанартай бүтээгдэхүүн гэдэг нь нөгөө талдаа хэмнэлт байгаад байгаа юм.

Д.Ж: Та хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй. Supervision гэж кабелийн суваг байгаа. Үүнийг та бараг эхлэж хийсэн хүмүүсийнх нь нэг. Тодорхой хүрээний бүр салдаггүй хэрэглэгчид байгаа. Мөн та SBN гэдэг телевизтэй. Худалдаа медиа гэсэн хоёр төрлийн бизнесийн харилцан уялдаа ямар байдаг юм бэ? Та хоёулангаар нь явах юмуу? Төрөлжих юмуу?

С.Б: Хэрвээ бид хятад шиг том зах зээлтэй бол нэг төрлийн биш бүр түүний нэг хэсэгт нь байхад л зах зээл хангалттай. Олон хүнтэй учраас. Гэтэл манайд бол улс төрийн бодлого тогтвортой биш, амархан тоглоомын дүрмээ өөрчилдөг, хуулиуд нь тэр дороо өөрчлөгддөг. Тэгснээ зах зээл нь жижигхэн. Ийм болохоор нэг төрлийн бизнес хийх нь эрсдэлтэй юм. Нөгөө талаар худалдаа үйлчилгээ бол хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй уялдаатай байдаг. Бие биеэ дэмжиж ажилладаг гэдэг утгаараа зөв шийдэл гэж бодоод байгаа юм. Кабелийн телевизийн хувьд бид нарт нэг их ашигтай бизнес биш. Яагаад гэвэл технологи асар хурдтайгаар үргэлж өөрчлөгдөж байгаа учраас хөрөнгө оруулалт өндөр. Гол нь хэрэглэгчиддээ соёлыг авчирсан байх. Дэлхийн нэртэй Discovery, спортын, entertainment, мэдээллийн сувгуудыг авчрахаар хүмүүсийн мэдэх, харах нь өөрчлөгдөж байсан. Тэр үед чинь интернет байхгүй байлаа шүү дээ. Тэгэхээр ард түмэндээ танин мэдүүлэх тал дээр тодорхой зүйл хийсэн болов уу гэж боддог.

Д.Ж: Та хүүхдүүд, ач зээ нартайгаа амьдардаг. Ийм том сүлжээ хариуцдаг. Энэ их ажлыг яаж амжуулаад байна? Ямар хобби байна? Яаж биеийн тамир хийж байна вэ?

С.Б: “Нас гэдэг бол тоо шүү дээ” гэж ярьдаг. Ер нь тийм. Япончууд 80 хүртлээ ажилладаг. Ер нь бол хүн ажиллаж, хамт олонтойгоо байж, хамт олноосоо суралцаж, хамт олондоо туршлагаасаа хуваалцаж, зогсолтгүй ном уншиж, өөрийгөө боловсруулж байж хүн төрөлхтөн явна. Японы нэгэн монголд элэгтэй шүүмжлэгч Айко сан хэлсэн байдаг. Оюуны хомсдолтой ядуурал гээд. Монголчууд тодорхой амжилтанд хүрээд зогсчих юмаа. Гэтэл насан туршийн боловсрол насан туршдаа л явах ёстой. Үүнийг залуучууддаа хандаж хэлмээр байгаа юм.

2018.02.03

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/s-boldkhet-boldkhet-sereeter> холбоосоор үзнэ үү.

Ангилалдаа анхдагч:

- Их бие. Цэргийн зориулалтын өндөр чанартай хөнгөн цагааны хайлш
- Орчныг бүрэн хянах 360 хэмийн камер болон 4L бартаат тохиргоонд ажиллах хос камер (урд, хойд)
- Тэвшний хаалгыг алсаас нээх удирдлага
- Хийн дэртэй зорчигчийн суудлын бүс

Ангилалдаа шилдэг:

- Хөдөлгүүр: 691мм мушгих хүч 450 морины хүч
- Хамгийн бага бензин зарцуулалт
- Ачих даац: 1.5тн
- Чирэх даац: 3.6тн



Цэргийн зориулалтын өндөр чанартай хөнгөн цагааны хайлшаар хийсэн их бие нь автомашины жинг 226.8 кг-р хөнгөрүүлсэн

Terran Modes



Baja

ЗАХИАЛГА АВЧ БАЙНА. Утас: 7011-3673, 9910-8368, 9910-6507, 9911-8375, 9911-8301 www.waa.mn

JARGAL DEFACTO


ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШ

The Defacto Gazette

➤ МОНГОЛ

➤ АНГЛИ

➤ ЯПОН





NEW NISSAN PATROL

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84 сар**

УРАМШУУЛАЛ:

Хамгаалалтын хууцаг

Сангит орсонын эрх

4x4 бөлийн дугуй

Салманы цэвэрлэх хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
 Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
 Баг: Батхүүгийн Амар
 Отгонсүрэнгийн Билгүүн
 Өсөхбаярын Биндэръяа
 Адъяагийн Тунгалаг
 Нямаагийн Цэнгэл

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
 ☎ +976 94109342
 🌐 www.defacto.mn